


"Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/398 дугаар албан бичгийн хавсралт"



Булган аймгийн соёл, урлаг, аялал жуулчлал,
залуучуудын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний
жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ,
үнэлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Нэг. Ерөнхий мэдээлэл

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан 12 зорилтын хүрээнд 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлгээ хийлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан, холбогдох бичиг, баримттай танилцах, хариуцсан албан хаагчдаас тодруулах, ярилцах зэрэг хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг аргыг ашиглав.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 86 арга хэмжээ хэрэгжүүлэхээр туссанаас хэрэгжилтийн дундаж 98.1 хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 4.1 хувиар өссөн гэж үнэлэгджээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үнэлгээ тус бүрээр үзүүлбэл:

-зорилт, арга хэмжээний хэрэгжилт хүрэх түвшинд хүрсэн, бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарч, гол үр дүн нь гарснаар 90-100 хувиар үнэлэгдсэн 84 арга хэмжээ,

-тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн тул 70.0 хувиар үнэлэгдсэн 1 арга хэмжээ,

-тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлсэн ч шийдвэрлэгдээгүй байгаа 1 арга хэмжээ "0" үнэлэгдсэн байна.

0 хувьтай байгаа арга хэмжээ нь хэрэгжүүлэх төсвийг орон нутгийн төсөвт тусгуулах санал хүргүүлсэн боловч батлагдаагүй тул хэрэгжээгүй байна.

Хоёр. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Соёлын сайд, Булган аймгийн Засаг дарга нарын 2024 онд хамтран ажиллах гэрээнд тулгуурлан, Соёлын салбарт хэрэгжих хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр 12 зорилт, 86 арга хэмжээтэйгээр боловсруулж батлуулсан.

Байгууллага, зохион байгуулалтын нэгжийн төлөвлөгөөнд үндэслэн төрийн захиргааны 4 албан хаагч дунджаар 23-27 арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнахаар гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулжээ.

Гурав. Арга хэмжээний хэрэгжилт

3.1 Амжилттай хэрэгжсэн арга хэмжээ: Дараах 6 арга хэмжээг хамгийн үр дүнтэй амжилттай хэрэгжсэн гэж үзэж байгаа ба үүнд тус газраас авч хэрэгжүүлсэн зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ нөлөөлсөн. Үүнд:

3.1.1 /1.1.2/, Аймгийн Төв номын сангийн шинэ барилгын ажил эхлүүлэхэд зураг төсвийг бэлэн болгож шаардлагатай материалыг хугацаанд нь Соёлын яам болон Сангийн яаманд хүргүүлснээр нийт 3.1 тэрбум үүнээс 2024 онд 1.5 тэрбум төгрөгийн барилгын ажил хийгдэхээр шийдүүлсэн. Барилгын гүйцэтгэгч шалгаруулах үнэлгээний хороонд байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн орж ажиллаж гүйцэтгэгч 3 сард шалгарсан .

3.1.2 /1.2.3/, Олон улсын болон улс, бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд театр, мэргэжлийн уран бүтээлчид, хүүхэд залуучуудыг оролцуулахад аймгийн удирдлагуудтай хамтран дэмжлэг үзүүлж ажилласнаар ОХУ-д зохион байгуулагдсан И.О.Дунаевскийн нэрэмжит Олон улсын уралдаанд Хөгжимт жүжгийн театрын дуучин Б.Гантөмөрт дэмжлэг үзүүлж оролцуулсан. Мөн Солонгос улсын Жэжү хотод зохион байгуулагдсан "Тамна" олон улсын наадамд ХЖТ-ын 8 уран бүтээлчийг оролцоход 19 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

3.1.3 /1.2.4/, Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах, сургалтад хамруулах гэсэн арга хэмжээг Соёлын яам бусад байгууллагатай хамтран ажилласнаар Хойд бүсийн Соёлын салбарын ажилтны зөвлөгөөнд 20 байгууллагын бүх албан хаагчдаа хамруулснаас гадна 2024 онд салбарын нийт ажиллагсад дунджаар 3 удаагийн сургалтанд хамрагдсан.

3.1.4 /1.6.4/, Өмнөх жилүүдэд зөвхөн Булган аймгийн хүүхэд, багачууд оролцдог байсан Булган хангай урлагийн наадмыг өргөжүүлэн "Булган хангай-2024" хойд бүсийн хүүхдийн урлагийн наадам болгож 8 төрөл, 4 насны ангиллаар зохион байгуулснаар Булган, Хөвсгөл, Орхон аймгийн 21 сумын 1100 гаруй хүүхэд оролцсон.

3.1.5 /1.6.6/, Булган аймагт зохион байгуулагдсан Буриад зоны Дэлхийн Алтаргана-XV наадмын соёл, урлагийн чиглэлийн 8 уралдааныг амжилттай зохион байгуулсан. Эдгээр уралдааныг зохион байгуулахад тус газар ОХУ-ын 3 муж болон БНХАУ, Монгол улсын Улаанбаатар хот, Хөвсгөл, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ,

Говьсүмбэр, Дархан-Уул аймгуудад суух Буриад ястанд тэмцээний удирдамжийг батлуулан хүргүүлсэн.

8 тэмцээн, уралдааныг зохион байгуулж ОХУ, ӨМӨЗО, Дорнод, Хэнтий, Улаанбаатар, Орхон, Хөвсгөл, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дархан-Уул аймгаас нийт 589 хүн оролцсон байна. Мөн “Алтарганы Үдэш” шоу тоглолт, “Ёохор наадаан” галын наадмыг тус тус зохион байгуулан 60.000 орчим хүн үзэж сонирхлоо. Аймгийн Музейгээс Буриад угсаатан” үзэсгэлэн болон “Айрагтай музей” хөтөлбөрийг хэрэгжүүлж 1249 хүнд үйлчлэн 4.6 сая төгрөгийн орлого олсон.

3.1.6 /1.3.6/, “Айраг фестиваль-2024” арга хэмжээний нээлт, хаалтын үйл ажиллагаа, төв тайзны үйл ажиллагаа, Гэр тоглолт, Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн Гэр үзэсгэлэн, “Айрагдъя” соёлын арга хэмжээг зохион байгуулсан.

3.2 Хангалтгүй хэрэгжсэн арга хэмжээ: Ардын Хатанбаатар Магсаржавын Дуулгат Бунханд засвар хийх зураг төсвийг хийлгэх арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн. Шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгуулахаар Аймгийн Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүсэлтийг хүргүүлсэн боловч 2024 оны төсөвт тусгагдаагүй.

3.3 Тухайн оны онцлог, шинэлэг арга хэмжээ: Дараах арга хэмжээнүүд олон аймгуудыг хамруулж чадсан байдлаараа өмнөх онуудын арга хэмжээнээс онцлог, шинэлэг, үр өгөөжтэй байлаа.

3.3.1 “Булган хангай-2024” хойд бүсийн хүүхдийн урлагийн наадам

3.3.2 Дэлхийн Алтаргана-XV наадам

3.3.3 Хойд бүсийн Соёлын салбарын ажилтны зөвлөгөөн

Дөрөв. Тайлагналт

Хэрэгжилтийн гүйцэтгэлийн тайланг Мэргэжилтэн-Нэгж-Байгууллага гэсэн дарааллаар боловсруулан эхний хагас жилийнхийг 06 дугаар сарын 13-ны өдөр, бүтэн жилийнхийг 12 дугаар сарын 05-ны өдөр программд байрлуулж 12 сарын 13 хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн байгууллагын хурлаар хэлэлцүүлж хүргүүлсэн.

Хэрэгжилтийн тайлангийн чанарыг сайжруулах зорилгоор 86 арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хэрэгжилтийн явцад шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон Соёлын яам болон аймаг, сумдын удирдлага, нэгж байгууллагуудтай хамтран ажилласны дүнд тодорхой үр дүн гарсан.

Төлөвлөгөөний тайлагналтаас харахад ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасан тайлангийн чанарт тавих “нийтлэг” болон “тусгай” шаардлагыг 82 арга хэмжээнийх “бүрэн”, 4 арга хэмжээнийх “дунд” зэрэг хангасан байна.

Тав. Дүгнэлт

Соёл урлаг аялал жуулчлал залуучуудын газар нь 2024 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 86 арга хэмжээтэй боловсруулан хэрэгжилтийг 98.1 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээтэйгээр хэрэгжүүлэн ажилласан байна.

Энэ онд “Дэлхийн Алтаргана-2024” олон улсын 15 дугаар наадам, Булган хангай-2024 Хойд бүсийн хүүхдийн урлагийн наадмыг амжилттай зохион байгуулсан, уран бүтээлчид, авьяаслаг хүүхдүүдийг дэмжиж олон улсын болон улс, бүсийн чанартай уралдаануудад оролцуулсан, улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс нийт 5.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татаж бүх соёлын байгууллагуудад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж олгож, 2 барилгын ажилыг шинээр эхлүүлэн, 3 байгууллагын барилгад их засвар хийлгэсэн онцлогтой жил байлаа.

Зургаа. Зөвлөмж

6.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт

6.1.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлагнах журам”, ЗГХЭГ-ын даргын 2020 оны Аргачлал батлах тухай 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулж хэвших,

6.1.2 Тухайн газрын чиг үүрэгт хамаарахгүй, хууль тогтоомжийн дагуу оролцох боломжгүй арга хэмжээ гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орж ирж байгааг цаашид анхаарах Тухайлбал: 2024 оны төлөвлөгөөнд Бүрэгхангай сумын Соёлын төвийн барилгын гүйцэтгэгч шалгаруулах тендэр нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт явагдсан нь тус газарт ямар ч хамааралгүй байсан бөгөөд зөвхөн сайтаас л явцыг харж байсан ч төлөвлөгөөнд тусгагдсан тул тайлагнах шаардлага гарч байсан.

**БУЛГАН АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР**